



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН
ХОРШООДЫН
2024 ОНЫ ХОЁРДУГААР
УЛИРЛЫН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР

УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	2
1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл.....	2
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....	3
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....	3
1.4 Бодлого, зохицуулалтын орчин.....	5
ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД	7
2.1 Статистик үзүүлэлтүүд.....	7
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....	9
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд...10	
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	11
ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	12
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....	12
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....	14
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....	14
3.4 Зээлийн чанарын талаар.....	14
ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	17
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....	17
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....	18
4.3 Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн талаар.....	19
4.4 Санхүүгийн бус өр төлбөр.....	20
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....	20
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....	21
ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА	21
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....	21
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....	22
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....	22
ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	23
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	23

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2024 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2024.08.05


Улаанбаатар хот

НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2024 оны 2 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 181 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11 ХЗХ буюу 5.7 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант улиралд нийт ХЗХ-дын 49.2 хувь буюу 89 ХЗХ орон нутагт, 50.8 хувь буюу 92 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

График 1: ХЗХ-дын тоо (хот, орон нутгаар)



ХЗХ-дын тоо сүүлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй буурсан боловч санхүүгийн болон статистик үзүүлэлтүүд харьцангуй тогтвортой байгаа нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг 4 улирал дараалан хангаагүй, өөрийн хөрөнгөгүй болсон,

хоршоологчдын өмчгүй болж үйл ажиллагаа доголдсон ХЗХ-дын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотой байна.

Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 3 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, 1 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг сэргээх, 3 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн 22 ХЗХ-ны 135 сонгуульт гишүүн, 2 ХЗХ-ны ажлын байрны хаягийн өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2020	2021	2022	2023	2024.И
ХЗХ-дын тоо	249	209	196	191	181
Шинээр олгосон	14	-	7	3	-
Хүчингүй болгосон	26	40	20	8	10
Түдгэлзүүлсэн	23	12	13	12	3
Сэргээсэн	6	1	3	1	2
ТЗ-ийн хугацаа сунгасан	49	85	62	-*	-*

*Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд 2023.01.06-ны өдөр оруулсан өөрчлөлтийн дагуу ХЗХ-ны тусгай зөвшөөрөл хугацаагүй болсон.

1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2024 оны 2 дугаар улирлын байдлаар 181 ХЗХ 61 салбар, 622 ажилтан, 74,186 гишүүн /73,895 иргэн, 291 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотод 92 ХЗХ Багахангай дүүргээс бусад дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9 ХЗХ буюу 8.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул дүүргүүдэд төвлөрөл хамгийн их байна.

Орон нутагт Сэлэнгэ аймгаас бусад 20 аймагт 89 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Сэлэнгэ аймагт тусгай зөвшөөрөлтэй ХЗХ байхгүй боловч нэр бүхий 1 ХЗХ-ны 6 салбар байна. Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Ховд, Дорнод аймгуудад төвлөрөл их байгаа бол Булган, Говьсүмбэр, Өвөрхангай аймагт тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 2: ХЗХ-дын тархалт



Зураг 1: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт



Зураг 3: ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл


1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл

2024 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,002 буюу 4.2 хувиар өсөж 74,186 хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 54.2 хувь буюу 40,195 нь эмэгтэй, 0.4 хувь буюу 291 нь хуулийн этгээд, үүний 38.8 хувь буюу 113 нь эмэгтэй удирдлагатай байна.



Нийт гишүүдийн 54.2 хувь буюу 40,245 гишүүн Улаанбаатар хотын ХЗХ-нд бүртгэлтэй бол 45.8 хувь буюу 33,941 гишүүн орон нутгийн ХЗХ-нд бүртгэлтэй байна.

График 2: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт (хот, орон нутгаар)



Сүүлийн 5 жилийн хугацаанд ХЗХ-дын тоо буурсан ч гишүүдийн тоо 2021 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеээс 2.1 хувиар өссөн бол 2023 оны 2 дугаар улирал хүртэл дунджаар 1.7 хувиар буурч, тайлант хугацаанд өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


Нийт 181 ХЗХ-ны 30.4 хувь буюу 55 ХЗХ 20-100 гишүүнтэй, 52.5 хувь буюу 95 ХЗХ 101-500 гишүүнтэй, 9.4 хувь буюу 17 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 7.7 хувь буюу 14 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна.

Хүснэгт 2: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд /интервалаар/	ХЗХ-ны тоо	Гишүүдийн тоо	Нийт гишүүдэд эзлэх хувь
20-100 гишүүнтэй	55	3,095	4.2%
101-500 гишүүнтэй	95	21,468	28.9%
501-1,000 гишүүнтэй	17	12,004	16.2%
1,001-ээс дээш гишүүнтэй	14	37,619	50.7%
Нийт	181	74,186	100.0%

Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 14 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 50.7 хувийг эзэлж байна.

График 3: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



1.4 Бодлого, зохицуулалтын орчин

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

- Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй ТА-6883 REG: “Хүртгээмжтэй, ногоон сэргэлтийн төлөө Зүүн Азид жендэрийн тэгш байдлыг эрчимжүүлэх” төслийн хүрээнд “Жендэрийн мэдрэмжтэй ногоон санхүүжилтийн чиглэлээр сургагч багш бэлтгэх” сургалтад Хорооны албан хаагчид болон Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооны төлөөлөл нийт 20 оролцогчийг хамруулан 2024 оны 06 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд зохион байгуулсан.
- Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (ACCU) болон Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоотой хамтран Монголын хадгаламж, зээлийн хоршоодын удирдлагын түвшинд сургагч багш бэлтгэх сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 17-20-ны өдрүүдэд зохион байгуулсан. Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (ACCU)-ны гүйцэтгэх захирал болон зөвлөхийг 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдөр хүлээн авч, салбарын хөгжил, чиг хандлага, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

Хууль, эрх зүйн орчин

- Сангийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг танилцуулах сургалтыг Сангийн яамтай хамтран Монголын

хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооны төлөөлөл болон хадгаламж, зээлийн хоршоодын гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, аудитын байгууллага, санхүүгийн програм хангамжийн компанийн төлөөлөл 145 оролцогчийг хамруулан 2024 оны 04 дүгээр сарын 11, 18-ны , 05 дугаар сарын 09-ний өдрүүдэд тус тус танхим болон цахимаар зохион байгуулсан.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 286 дугаар тогтоолоор “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийг шинэчлэн баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6880 дугаарт бүртгүүлсэн.
- “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 254 тоот тушаалаар баталсан. Журмыг баталснаар хадгаламж, зээлийн хоршооны хяналтыг эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоонд шилжүүлээ.

Хурал семинар, уулзалт


- Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 384 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-ын 2.1.16-д заасны дагуу Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооноос хадгаламж, зээлийн хоршоодын зээлийн хорооны гишүүдэд 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан “Хадгаламж, зээлийн хоршооны

зээлийн үйл ажиллагаа” сэдэвт сургалтад “Банкнаас бусад санхүүгийн зах зээлийн тойм”, “Тогтвортой санхүүгийн суурь ойлголт, олон улсын чиг хандлага” сэдвээр мэдээлэл өгч, 23 оролцогчид гэрчилгээ олгосон.

- Монголын хуульчдын холбооноос 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсан “Хуульчийн Про Боно өдөр 2024”-т оролцож иргэдэд хадгаламж, зээлийн хоршооны хууль эрх зүйн орчны талаар мэдээлэл өгсөн.
- Улсын Их Хурлын даргын ивээл дор зохион байгуулагдсан “Номын баяр”-т 2024 оны 05 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд оролцож иргэдэд хадгаламж, зээлийн хоршооны салбарын талаар мэдээлэл, зөвлөгөө өгсөн.
- Бичил санхүүгийн бодлогын зөвлөлийн ээлжит хурлыг 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдөр хуралдуулж салбарын өнөөгийн нөхцөл байдал, хяналт шалгалт, зохицуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэрэг сэдвээр мэдээлэл өгч, хэлэлцүүлсэн.

Нийт гишүүдийн 43.7 хувь дээд боловсрол эзэмшсэн байна. Гишүүдийн боловсролын түвшинг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс өндөр буюу дээд боловсролтой нийт гишүүдийн 67.1 хувь Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд байна.

График 5: ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин, УБ, орон нутгаар



Хүснэгт 4: ХЗХ-дын зээлдэгчдийн статистик үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт зээлдэгч		Үүнээс:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	181	100.0%	92	50.8%	89	49.2%
Нийт зээлийн үлдэгдэл	243,337,611.42	100.0%	184,262,662.61	75.7%	59,074,948.81	24.3%
Нийт зээлдэгчийн тоо	29,936	100.0%	13,746	45.9%	16,190	54.1%
Иргэн	29,833	99.7%	13,656	99.3%	16,177	99.9%
Эмэгтэй	16,988	56.7%	7,982	58.1%	9,006	55.6%
Хуулийн этгээд	103	0.3%	90	0.7%	13	0.1%
Эмэгтэй удирдлагатай	43	41.7%	29	0.2%	14	0.1%
Зээлдэгчдийн насжилт	29,833	100.0%	13,656	45.8%	16,177	54.2%
18-35 насны	8,302	27.8%	4,301	31.5%	4,001	24.7%
36-45 насны	8,758	29.4%	3,890	28.5%	4,868	30.1%
46-55 насны	7,538	25.3%	3,181	23.3%	4,357	26.9%
55-аас дээш	5,235	17.5%	2,284	16.7%	2,951	18.2%
Зээлдэгчдийн боловсрол	29,833	100.0%	13,656	45.8%	16,177	54.2%
Дээд	11,537	38.7%	6,524	47.8%	5,013	31.0%
Тусгай дунд	4,966	16.6%	2,426	17.8%	2,540	15.7%
Бүрэн дунд	7,339	24.6%	2,214	16.2%	5,125	31.7%
Дунд	4,668	15.6%	2,418	17.7%	2,250	13.9%
Бага	1,323	4.4%	74	0.5%	1,249	7.7%

Тайлант улиралд ХЗХ-д 29,936 зээлдэгчийн 243,337,611.42 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлдэгчийн 45.9 хувь буюу 13,746 зээлдэгч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 75.7 хувь буюу 184,262,662.61 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 54.1 хувь буюу 16,190 зээлдэгч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 24.3 хувь буюу

59,074,948.81 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

Нийт зээлдэгчийн 99.7 хувь буюу 29,833 нь хувь хүн (56.7 хувь буюу 16,988 нь эмэгтэй), 0.3 хувь буюу 103 нь хуулийн этгээд байна.

Нэг зээлдэгчид ногдох дундаж зээл 8,128.59 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 13,404.82 мянган төгрөг, орон нутагт 3,648.85 мянган төгрөг байна.

Хүснэгт 5: ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт хадгаламж эзэмшигч		Үүнээс:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	181	100.0%	92	50.8%	89	49.2%
Нийт хадгаламжийн үлдэгдэл	226,125,305.89	100.0%	176,993,055.92	78.3%	49,132,249.97	21.7%
Нийт хадгаламж эзэмшигчийн тоо	43,466	100.0%	23,228	53.4%	20,238	46.6%
Иргэн	25,740	56.4%	12,872	53.7%	12,868	59.4%
Эмэгтэй	24,234	55.8%	12,197	52.5%	12,037	59.5%
Хуулийн этгээд	60	0.1%	30	0.1%	30	0.1%
Эмэгтэй удирдлагатай	28	0.1%	10	0.0%	18	0.1%

Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	4,996,534.17	2.2%	4,216,657.91	2.4%	779,876.27	1.6%
Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо	5,082	11.7%	3,982	17.1%	1,100	5.4%
Иргэн	5,063	11.6%	3,963	17.1%	1,100	5.4%
Хуулийн этгээд	19	0.0%	19	0.1%	-	0.0%
Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	221,128,771.72	97.8%	172,776,398.02	97.6%	48,352,373.70	98.4%
Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо	38,384	88.3%	19,246	82.9%	19,138	94.6%
Иргэн	38,343	88.2%	19,235	82.8%	19,108	94.4%
Хуулийн этгээд	41	0.1%	11	0.0%	30	0.1%
Хадгаламж эзэмшигчдийн насжилт	45,556	100.0%	23,920	100.0%	21,636	100.0%
18-35 насны	17,127	37.6%	10,941	45.7%	6,186	28.6%
36-45 насны	11,544	25.3%	5,500	23.0%	6,044	27.9%
46-55 насны	9,339	20.5%	4,131	17.3%	5,208	24.1%
56-аас дээш	7,546	16.6%	3,348	14.0%	4,198	19.4%
Хадгаламж эзэмшигчдийн боловсрол	45,556	100.0%	23,920	100.0%	21,636	100.0%
Дээд	20,420	44.8%	13,788	57.6%	6,632	30.7%
Тусгай дунд	6,985	15.3%	3,963	16.6%	3,022	14.0%
Бүрэн дунд	9,729	21.4%	3,872	16.2%	5,857	27.1%
Дунд	5,067	11.1%	979	4.1%	4,088	18.9%
Бага	3,355	7.4%	1,318	5.5%	2,037	9.4%

2024 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-д 43,466 хадгаламж эзэмшигчийн 226,125,305.89 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 53.4 хувь буюу 23,228 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 78.3 хувь буюу 176,993,055.92 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 46.6 хувь буюу 20,238 хадгаламж эзэмшигч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 21.7 хувь буюу 49,132,249.97 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2024 оны 2 дугаар улирлын байдлаар зах зээлийн нийт хөрөнгө 327,802,063.60 мянган төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.8 хувь буюу 31,869,479.89 мянган төгрөгөөр өсөж, банкны зах зээлийн 0.5 хувьтай тэнцэж байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 10.4 хувь буюу 22,933,528.68 мянган төгрөгөөр, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 10.9 хувь буюу 22,227,548.26 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 19.0 хувь буюу 5,745,047.36 мянган төгрөгөөр, нийт зарлага 9.7 хувь буюу 2,663,266.36 мянган

Нийт хадгаламж эзэмшигчийн 11.7 хувийг хугацаагүй, 88.3 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 99.9 хувь буюу 43,406 нь хувь хүн (55.8 хувь буюу 24,234 нь эмэгтэй), 0.1 хувь буюу 60 нь хуулийн этгээд (0.1 хувь буюу 28 нь эмэгтэй удирдлагатай) байна.

Нэг хадгаламж эзэмшигчид ногдох дундаж хадгаламж 5,202.35 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 7,619.81 мянган төгрөг, орон нутагт 2,427.72 мянган төгрөг байна.

төгрөгөөр нэмэгдэж нийт цэвэр орлого 5,834,916.10 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай нийт ХЗХ-дын 59.7 хувь буюу 108 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 6: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2023 оны II улирал	2024 оны II улирал	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Нийт хөрөнгө	295,932,583.62	327,802,063.60		
Банкны салбарт эзлэх хувь	0.6%	0.5%	31,869,479.98	10.8%
Нийт зээл	220,404,082.74	243,337,611.42		
Банкны салбарт эзлэх хувь	0.9%	0.7%	22,933,528.68	10.4%
Нийт чанаргүй зээл	7,269,514.45	6,824,289.53		
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.3%	2.8%	-445,224.92	-6.1%
Банкны салбарт эзлэх хувь	0.3%	0.4%	-0.5%	-15.0%
			0.0%	6.3%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	203,897,757.63	226,125,305.89		
Банкны салбарт эзлэх хувь	1.1%	1.0%	22,227,548.26	10.9%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	27,241,446.91	28,554,180.27		
Нийт хоршоологчдын өмч	34,218,707.94	44,263,345.75		
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	13,734,424.36	7,765,682.24		
Нийт орлого	30,278,086.05	36,023,133.41	-5,968,742.12	-43.5%
Нийт зарлага	27,524,950.95	30,188,217.31		
Цэвэр орлого, алдагдал	2,753,135.10	5,834,916.10	3,081,781.00	111.9%

2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 92 ХЗХ-ны нийт хөрөнгө 254,687,387.38 мянган төгрөг нь зах зээлийн 77.7 хувь, нийт зээл 184,262,662.61 мянган төгрөг нь зах зээлийн 75.7 хувь, нийт хадгаламж 176,993,055.92 мянган төгрөг нь зах зээлийн 78.3 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.7 хувь буюу 731,400.78 мянган төгрөгөөр буурч 5,536,563.30 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 3.0 хувийг эзэлж байна. Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 43.8 хувь буюу

5,960,505.42 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 20.4 хувь буюу 4,493,913.20 мянган төгрөгөөр, нийт зарлага 7.0 хувь буюу 1,458,224.99 мянган төгрөгөөр тус тус өсөж, цэвэр орлого 4,173,789.32 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай Улаанбаатар хотын ХЗХ-дын 52.8 хувь буюу 57 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 7: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2023 оны II улирал	2024 оны II улирал	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Нийт хөрөнгө	234,355,743.80	254,687,387.38	20,331,643.58	8.7%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	79.2%	77.7%	-1.5%	-1.9%
Нийт зээл	170,395,599.16	184,262,662.61	13,867,063.45	8.1%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	77.3%	75.7%	-1.6%	-2.1%
Нийт чанаргүй зээл	6,267,964.07	5,536,563.30	-731,400.78	-11.7%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	86.2%	81.1%	-5.1%	-5.9%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.7%	3.0%	-0.7%	-18.3%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	163,059,077.86	176,993,055.92	13,933,978.06	8.5%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	80.0%	78.3%	-1.7%	-2.1%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	19,977,387.39	20,601,184.12	623,796.74	3.1%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	73.3%	72.1%	-1.2%	-1.6%
Нийт хоршоологчдын өмч	24,602,147.41	32,998,560.84	8,396,413.43	34.1%

ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	71.9%	74.6%	2.7%	3.7%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	13,594,424.36	7,633,918.95	-5,960,505.42	-43.8%
Нийт орлого	22,031,379.08	26,525,292.28	4,493,913.20	20.4%
Нийт зарлага	20,893,277.97	22,351,502.96	1,458,224.99	7.0%
Цэвэр орлого, алдагдал	1,138,101.12	4,173,789.32	3,035,688.21	266.7%

2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 89 ХЗХ-ны нийт хөрөнгө 73,114,676.22 мянган төгрөг нь зах зээлийн 22.3 хувь, нийт зээлийн үлдэгдэл 59,074,948.81 мянган төгрөг нь зах зээлийн 24.3 хувь, нийт хадгаламж 49,132,249.97 мянган төгрөг нь зах зээлийн 21.7 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 15.2 хувь буюу 1,251,134.16 мянган төгрөгөөр, нийт зарлага 18.2 хувь буюу 1,205,041.37 мянган төгрөгөөр тус тус өсөж, нийт цэвэр орлого

1,661,126.77 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай орон нутгийн ХЗХ-дын 47.2 хувь буюу 51 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 8: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2023 оны II улирал	2024 оны II улирал	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Нийт хөрөнгө	61,576,839.83	73,114,676.22	11,537,836.40	18.7%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	20.8%	22.3%	1.5%	7.2%
Нийт зээл	50,008,483.58	59,074,948.81	9,066,465.23	18.1%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	22.7%	24.3%	1.6%	7.0%
Нийт чанаргүй зээл	1,001,550.38	1,287,726.23	286,175.85	28.6%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	13.8%	18.9%	5.1%	37.0%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	0.6%	0.7%	0.1%	18.9%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	40,838,679.77	49,132,249.97	8,293,570.20	20.3%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	20.0%	21.7%	1.7%	8.5%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	7,264,059.52	7,952,996.14	688,936.62	9.5%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	26.7%	27.9%	1.2%	4.5%
Нийт хоршоологчдын өмч	9,616,560.53	11,264,784.91	1,648,224.38	17.1%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	28.1%	25.4%	-2.7%	-9.4%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	140,000.00	131,763.30	-8,236.70	-5.9%
Нийт орлого	8,246,706.96	9,497,841.12	1,251,134.16	15.2%
Нийт зарлага	6,631,672.98	7,836,714.35	1,205,041.37	18.2%
Цэвэр орлого, алдагдал	1,615,033.98	1,661,126.77	46,092.79	2.9%

ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Сангийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх аж ахуй нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталсан. Журам шинэчлэн баталсантай холбоотойгоор хадгаламж болон зээлийг хүлээн зөвшөөрөх хэмжилтийн сууриуд, үнэ цэнийн өсөлт бууралт, хүүг хуримтлуулан

тооцох, шимтгэл хураамжийг хойшлуулан бүртгэх, тэнцлээс хасах, тэнцлээс хассан зээлийн орлогыг хүлээн зөвшөөрөх, эрсдэлийн санг СТОУС-ын дагуу ангилах, бүртгэлийн арга хандлагыг нарийвчлан зохицуулж, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга бэлтгэх заавар, дансны жагсаалтыг шинэчилсэн ба ерөнхий данс, үндсэн дансанд орсон өөрчлөлтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 9: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц (мянган төгрөгөөр)

ХӨРӨНГӨ	2023 оны II улирал		ХӨРӨНГӨ	2024 оны II улирал	
	Дүн	Хувь		Дүн	Хувь
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	291,800,966.79	98.6%	САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ	318,612,812.71	97.2%
Мөнгөн хөрөнгө	52,220,645.18	17.6%	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	65,829,773.21	20.1%
Бэлэн мөнгө	5,382,160.25	1.8%	Бэлэн мөнгө	3,659,524.30	1.1%
Банкинд байршуулсан харилцах	9,659,812.07	3.3%	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах	15,828,782.34	4.8%
Банкинд байршуулсан хадгаламж	37,178,672.86	12.6%	Банканд байршуулсан хадгаламж	2,807,172.66	13.1%
			Замд яваа мөнгө	11,762.53	4.8%
			Мөнгөтэй адилтгах хөрөнгө	-	0.0%
			Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	3,522,531.37	1.1%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	700,000.00	0.2%			
Арилжааны үнэт цаас	700,000.00	0.2%			
Зээл /цэвэр/	215,731,235.92	72.9%	Зээл /цэвэр/	246,642,405.96	75.2%
Нийт зээл	220,404,082.74	74.5%	Нийт зээл	243,337,611.42	74.2%
Хэвийн зээл	205,100,490.80	69.3%	Хэвийн зээл	229,313,103.31	70.0%
Хугацаа хэтэрсэн зээл	8,034,077.49	2.7%	Хугацаа хэтэрсэн зээл	7,200,218.58	2.2%
Чанаргүй зээл	7,269,514.45	2.5%	Чанаргүй зээл	6,824,289.53	2.1%
			Зээлийн хойшлогдсон орлого	0	0.0%
			Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	8,204,030.84	2.5%
(Зээлийн эрсдэлийн сан)	4,672,846.82	1.6%	(Зээлийн эрсдэлийн сан)	4,899,236.30	1.5%
			Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга	0	0.0%
Авлага	16,663,394.91	5.6%			
Байгууллага, хүмүүсээс авах авлага	7,228,231.56	2.4%			
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	9,435,163.34	3.2%			
Бусад эргэлтийн хөрөнгө	5,477,544.44	1.9%	Бусад санхүүгийн хөрөнгө	6,140,633.54	1.9%
Татварын авлага	8,001.46	0.0%	Дансны авлага /цэвэр/	1,664,685.26	0.5%
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	4,919,136.95	1.7%	Дансны авлага	1,664,685.26	0.5%
Дараа тайлангийн тооцоо	131,964.10	0.0%	Хувь хүнээс авах авлага	749,803.62	0.2%
Дутагдал, шамшигдал	61,653.20	0.0%	Хуулийн этгээдээс авах авлага (Авлагын эрсдэлийн сан)	914,881.63	0.3%
Хангамжийн зүйлс	354,174.72	0.1%		-	0.0%
Салбар хоорондын авлага	2,614.00	0.0%	Холбоотой талаас авах авлага	3,752,965.00	1.1%
			Ажиллагчдаас авах авлага	8,511.80	0.0%
			Салбар хоорондын тооцоо	-	0.0%
			Өмчлөх бусад санхүүгийн хөрөнгө /цэврээр/	142,409.62	0.0%
			Бусад	572,061.88	0.2%

Өмчлөх бусад хөрөнгө /цэвэр/	1,008,146.35	0.3%			
Өмчлөх бусад хөрөнгө	1,048,435.40	0.4%			
(Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулга)	40,289.05	0.0%			
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	4,131,616.83	1.4%	САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ	9,189,250.89	2.8%
Үндсэн хөрөнгө /цэвэр/	3,964,031.34	1.3%	Татварын авлага	405,170.63	0.1%
Биет бус хөрөнгө	152,032.81	0.1%	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага	4,038.82	0.0%
Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	15,552.69	0.0%	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,232,037.89	1.0%
			Бараа материал	291,592.95	0.1%
			Өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	674,508.42	0.2%
			Бусад санхүүгийн бус хөрөнгө	122,914.28	0.0%
			Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /цэврээр/	-	0.0%
			Үндсэн хөрөнгө /цэврээр/	4,343,012.23	1.3%
			Биет бус хөрөнгө /цэврээр/	115,975.67	0.0%
ХӨРӨНГИЙН ДҮН	295,932,583.62	100.0%	ХӨРӨНГИЙН ДҮН	327,802,063.60	100.0%

2024 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 327,802,063.60 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.8 хувь буюу 31,869,479.98 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 97.2 хувийг санхүүгийн хөрөнгө, 2.8 хувийг санхүүгийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нийт хөрөнгийн 20.1 хувийг, цэвэр зээл 75.2 хувийг тус тус эзэлж байна. Зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.3 хувиар өссөн байна.

Зураг 4: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс (мянган төгрөгөөр)




Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 10.4 хувь буюу 22,933,528.68 мянган төгрөгөөр өсөж 243,337,611.42 мянган

төгрөгт хүрсэн бөгөөд 4,899,236.30 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна. Харин хугацаа хэтэрсэн зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.4 хувь буюу 833,858.91 мянган төгрөгөөр буурч 7,200,218.58 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад 2020 оны 2 дугаар улирлаас тайлант улирал хүртэлх хугацаанд тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын тоо тогтмол буурсан ч хөрөнгийн хэмжээ дунджаар 9.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

График 6: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/



3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 4 ХЗХ-ны нийт хөрөнгө 189,650,400.41 мянган төгрөг ба зах зээлийн нийт хөрөнгийн 57.9 хувийг, гишүүдийн тоо 19,582 байгаа нь нийт гишүүдийн 26.4 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар (мянган төгрөгөөр)

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө		Гишүүд	
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	4	189,650,400.41	57.9%	19,582	26.4%
2	1,000,000.0 -10,000,000.0	31	102,066,769.40	31.1%	27,253	36.7%
3	500,000.0-1,000,000.0	23	16,732,147.38	5.1%	10,860	14.6%
4	100,000.0-500,000.0	68	15,958,111.40	4.9%	12,080	16.3%
5	50,000.0-100,000.0	39	2,962,508.19	0.9%	3,513	4.7%
6	10,000.0-50,000.0	14	421,307.46	0.1%	828	1.1%
7	10,000.0 хүртэл	2	10,819.35	0.00%	70	0.1%
Нийт дүн		181	327,802,063.60	100.0%	74,186	100.0%

10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 4 ХЗХ

ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн 57.9%

Нийт гишүүдийн 26.4%

3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээл дэх нийт зээлийн үлдэгдэл 243,337,611.42 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 74.2 хувь, зээлийн үлдэгдэл 246,642,405.96 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 75.2 хувийг тус тус эзэлж байна. Нягтлан бодох бүртгэлийн журам шинэчлэгдсэнээр цэвэр зээлийн үндсэн дансанд хамаарах бусад нэрийн дансуудыг нэмэгдсэнээр тооцоолсон болно.

Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.21 хувь, тайлант хугацаанд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2.25 хувь байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 31 ХЗХ-ны зээлийн дүн зах

зээлийн нийт зээлийн 87.1 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар (мянган төгрөгөөр)

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	31	212,006,235.81	87.1%
2	500,000.0-1,000,000.0	20	13,713,823.50	5.6%
3	100,000.0-500,000.0	66	14,357,093.89	5.9%
4	50,000.0-100,000.0	32	2,336,802.22	1.0%
5	10,000.0-50,000.0	28	905,682.93	0.4%
6	10,000.0 хүртэл	3	17,973.06	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	1	-	-
Нийт дүн		181	243,337,611.42	100%

3.4 Зээлийн чанарын талаар

Хүснэгт 12: Зээлийн ангиллын мэдээлэл (мянган төгрөгөөр)

Зээлийн ангиллын мэдээлэл	Зээлдэгчийн мэдээлэл		Зээлийн үлдэгдэл	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт	29,936	100.0%	243,337,611.42	100.0%
Хэвийн	27,758	92.7%	229,313,103.31	94.2%
Хугацаа хэтэрсэн	938	3.1%	7,200,218.58	3.0%
Чанаргүй	1,240	4.1%	6,824,289.53	2.8%
Хэвийн бус	391	31.5%	2,252,840.29	33.0%
Эргэлзээтэй	251	20.2%	1,384,407.71	20.3%
Муу	598	48.2%	3,187,041.52	46.7%

2024 оны 2 дугаар улирлын байдлаар зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 94.2 хувь буюу 229,313,103.31 мянган төгрөгийг хэвийн зээл, 3.0 хувь буюу


7,200,218.58 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 2.8 хувь буюу 6,824,289.53 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тайлант

